



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 43

Номгон

Баянхонгор сумын ерөнхий боловсролын
сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд хяналт,
шалгалт хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 21 дүгээр зүйлийн 21.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа, ерөнхий төлөв байдал, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Э.Цэнд-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Нарийн бичгийн дарга: Н.Одончимэг-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Д.Цэрэнхорлоо-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Ж.Хүрэлбаатар-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Н.Баярсайхан-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

Д.Ууганцэцэг-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

Б.Тэгшбаяр-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны Тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн

2. Удирдамжийн дагуу хяналт, шалгалтыг зохион байгуулж, үнэн зөв бодит дүгнэлт гарган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Э.Цэнд/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР